



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Дадал сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2024/222/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: open.audit.mn Чингис хот 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn Аудитын менежер: Д.Оюунтуяа Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn Ахлах аудитор: Г.Энх-Амгалан Утас: 91119424 Цахим хаяг: Ekh-Amgalang@audit.gov.mn Өндөрхаан итгэл аудит ХХК Аудитор: Б.Маналсүрэн Утас: 97066677 Цахим хаяг: Undurkhaanitgel@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг  
Утас: 70-56-21-12, Факс: 70-56-21-12  
E-mail: [khentii@audit.gov.mn](mailto:khentii@audit.gov.mn)

2024.05.14

№

346

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН ДАДАЛ  
СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ Н.ОДГАРАВ ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Дадал сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Хэнтий аймгийн Дадал сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант онд 3 удаа эд хариуцагч өөрчлөгдөх үед хөрөнгийн тооллого хийж тооцоо бодоогүй, хүүхдийн хоолны 1 хүүхдэд ногдох зардлыг норм, нормативаас илүү зарцуулсан, хүнсний материалыг ихээр нөөцөлж үлдэгдлийг өмнөх оноос 7,4 дахин нэмэгдүүлсэн нийт 18,024.1 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Аудитаар илэрсэн материаллаг зөрчлийн дүн урьдчилан тооцсон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллагын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлангаар мөнгөн хөрөнгө 75,099.5 мянган төгрөг, бараа материал

232420456

69,468.9 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 421,447.9 мянган төгрөгийн тус тус үлдэгдэлтэй, нийт 566,016.3 мянган төгрөгийн хөрөнгөтэй байна.

Тайлант онд улсын төсвөөс 654,645.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 106,232.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 692,152.2 мянган төгрөг зарцуулсан байна.

### **Аудитын гол асуудал**

Тус байгууллагын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 18,024.1 мянган төгрөгийн 3 зөрчил илэрч 772.5 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 17,251.6 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүллээ.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 47 арга хэмжээ тусгагдаж, 90.2 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамаарахгүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>54,546,301.74</b>	<b>144,568,437.55</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	6,374,503.76	75,099,545.57
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	6,374,503.76	75,099,545.57
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	6,374,503.76	75,099,545.57
31211	Төрийн сангийн харилцах	6,374,503.76	75,099,545.57
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	48,171,797.98	69,468,891.98
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	31,000.00	31,000.00
35130	Эм боох материал	31,000.00	31,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	48,140,797.98	69,437,891.98
35410	Бичиг хэргийн материал	500,200.00	319,100.00
35420	Аж ахуйн материал	46,002,597.98	52,011,697.98
35440	Түлш, шатах тослох материал	375,000.00	-
35460	Хүнсний материал	1,263,000.00	17,107,094.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>400,718,341.93</b>	<b>421,447,911.31</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	400,718,341.93	421,447,911.31
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	391,712,341.93	412,441,911.31
39201	Барилга, байгууламж, орон сууц	369,985,400.00	369,985,400.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(46,347,483.20)	(55,484,354.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	78,858,531.42	108,090,751.42
39206	Хуримтлагдсан элэгдэл	(36,497,634.03)	(45,128,305.25)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	50,344,169.76	65,180,695.76
39208	Хуримтлагдсан элэгдэл	(30,335,907.68)	(35,907,542.28)
39214	Бусад үндсэн хөрөнгө	21,969,705.66	21,969,705.66
39215	Хуримтлагдсан элэгдэл	(16,264,440.00)	(16,264,440.00)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	9,006,000.00	9,006,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	9,006,000.00	9,006,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>455,264,643.67</b>	<b>566,016,348.86</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>455,264,643.67</b>	<b>566,016,348.86</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	582,277,230.28	582,277,230.28
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(129,611,544.64)	(18,859,839.45)
51210	Өмнөх үеийн үр дүн	(129,611,544.64)	(129,611,544.64)
51220	Тайлант үеийн үр дүн	-	110,751,705.19
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,598,958.03	2,598,958.03
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>455,264,643.67</b>	<b>566,016,348.86</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>972,236,224.42</b>	<b>804,945,946.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>471,872,724.42</b>	<b>44,068,746.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>471,872,724.42</b>	<b>44,068,746.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	103,500.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	103,500.00	-
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Үндсэн хөрөнгө	415,684,811.42	44,068,746.00
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Бараа материал	56,084,413.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>500,363,500.00</b>	<b>760,877,200.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>438,896,900.00</b>	<b>654,645,200.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	438,896,900.00	654,645,200.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>61,466,600.00</b>	<b>106,232,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	61,466,600.00	106,232,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>516,971,580.75</b>	<b>694,194,240.81</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>516,971,580.75</b>	<b>694,194,240.81</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>514,082,553.58</b>	<b>694,194,240.81</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>340,907,589.00</b>	<b>424,038,953.36</b>
210101	Үндсэн цалин	244,100,144.00	276,148,841.46
210102	Нэмэгдэл	76,612,357.00	141,645,598.90
210104	Урамшуулал	6,413,406.00	6,244,513.00
210105	Гэрээт ажлын хөлс	13,781,682.00	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>42,638,732.50</b>	<b>53,337,862.83</b>
210201	Тэтгэврийн даатгал	28,932,996.50	35,831,078.72
210202	Тэтгэмжийн даатгал	3,478,108.27	4,393,660.82
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,723,102.73	3,497,268.42
210204	Ажилгүйдлийн даатгал	696,760.82	871,127.12
210205	Эрүүл мэндийн даатгал	6,807,764.18	8,744,727.75
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>39,789,787.57</b>	<b>84,797,700.00</b>
210301	Гэрэл, пахилгаан	17,321,811.57	54,326,615.00
210302	Түлш, халаалт	22,467,976.00	30,471,085.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,336,015.00</b>	<b>1,770,840.00</b>
210401	Бичиг хэрэг	-	1,068,600.00
210402	Тээвэр, шатахуун	897,215.00	702,240.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	117,600.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	321,200.00	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>52,893,774.00</b>	<b>67,160,556.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	85,300.00
210502	Хоол, хүнс	52,893,774.00	67,075,256.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,542,190.00</b>	<b>21,846,800.00</b>
210604	Урсгал засвар	3,542,190.00	21,846,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,110,000.00</b>	<b>817,000.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,110,000.00	817,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>31,864,465.51</b>	<b>40,424,528.62</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,192,730.36	14,163,952.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,000,000.00	2,921,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	20,671,735.15	23,339,176.62
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,889,027.17</b>	<b>-</b>
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>2,889,027.17</b>	<b>-</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,889,027.17	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>455,264,643.67</b>	<b>110,751,705.19</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>455,264,643.67</b>	<b>110,751,705.19</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>500,467,000.00</b>	<b>760,877,200.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>103,500.00</b>	-
120	Нийтлэг татварын бус орлого	103,500.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	103,500.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	103,500.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>500,363,500.00</b>	<b>760,877,200.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>438,896,900.00</b>	<b>654,645,200.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	438,896,900.00	654,645,200.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>61,466,600.00</b>	<b>106,232,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	61,466,600.00	106,232,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>494,092,496.24</b>	<b>692,152,158.19</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>494,092,496.24</b>	<b>692,152,158.19</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>491,203,469.07</b>	<b>692,152,158.19</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>340,907,589.00</b>	<b>423,630,771.18</b>
210101	Үндсэн цалин	244,100,144.00	275,740,659.28
210102	Нэмэгдэл	76,612,357.00	141,645,598.90
210104	Урамшуулал	6,413,406.00	6,244,513.00
210105	Гэрээт ажлын хөлс	13,781,682.00	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>42,638,732.50</b>	<b>53,746,045.01</b>
210201	Тэтгэврийн даатгал	28,932,996.50	36,239,260.90
210202	Тэтгэмжийн даатгал	3,478,108.27	4,393,660.82
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,723,102.73	3,497,268.42
210204	Ажилгүйдлийн даатгал	696,760.82	871,127.12
210205	Эрүүд мэндийн даатгал	6,807,764.18	8,744,727.75
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>39,209,787.57</b>	<b>84,385,200.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	17,321,811.57	55,353,500.00
210302	Түлш, халаалт	21,887,976.00	29,031,700.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>321,200.00</b>	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	321,200.00	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>49,721,335.00</b>	<b>82,919,350.00</b>
210502	Хоол, хүнс	49,721,335.00	82,919,350.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,542,190.00</b>	<b>21,846,800.00</b>
210604	Урсгал засвар	3,542,190.00	21,846,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,110,000.00</b>	<b>1,357,000.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,110,000.00	1,357,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>13,752,635.00</b>	<b>24,266,992.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,752,635.00	20,195,592.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,000,000.00	4,071,400.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,889,027.17</b>	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>2,889,027.17</b>	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,889,027.17	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>6,374,503.76</b>	<b>68,725,041.81</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>6,374,503.76</b>	<b>68,725,041.81</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>6,374,503.76</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>6,374,503.76</b>	<b>75,099,545.57</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	582,277,230.28	2,598,958.03	(590,581,455.97)	(5,705,267.66)
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	582,277,230.28	2,598,958.03	(590,581,455.97)	(5,705,267.66)
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	455,264,643.67	455,264,643.67
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	582,277,230.28	2,598,958.03	(135,316,812.30)	449,559,376.01
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	582,277,230.28	2,598,958.03	(135,316,812.30)	449,559,376.01
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	5,705,265.66	5,705,265.66
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	582,277,230.28	2,598,958.03	(129,611,546.64)	455,264,641.67
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	110,751,705.19	110,751,705.19
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	582,277,230.28	2,598,958.03	(18,859,841.45)	566,016,346.86

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	767,251,600.00	692,152,158.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	767,251,600.00	692,152,158.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	767,251,600.00	692,152,158.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	488,471,600.00	423,630,771.18
210101	Үндсэн цалин	336,582,800.00	275,740,659.28
210102	Нэмэгдэл	145,151,200.00	141,645,598.90
210104	Урамшуулал	6,737,600.00	6,244,513.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,058,700.00	53,746,045.01
210201	Тэтгэврийн даатгал	41,520,100.00	36,239,260.90
210202	Тэтгэмжийн даатгал	4,884,600.00	4,393,660.82
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,907,300.00	3,497,268.42
210204	Ажилгүйдлийн даатгал	977,300.00	871,127.12
210205	Эрүүл мэндийн даатгал	9,769,400.00	8,744,727.75
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	84,385,200.00	84,385,200.00
210301	Гэрэл, цахилгаан	55,353,500.00	55,353,500.00
210302	Түлш, халаалт	29,031,700.00	29,031,700.00
2105	Нормативт зардал	85,830,000.00	82,919,350.00
210502	Хоол, хүнс	85,830,000.00	82,919,350.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,846,800.00	21,846,800.00
210604	Урсгал засвар	21,846,800.00	21,846,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,357,200.00	1,357,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,357,200.00	1,357,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,302,100.00	24,266,992.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,230,600.00	20,195,592.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,071,500.00	4,071,400.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>767,251,600.00</b>	<b>760,877,200.00</b>
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	654,645,200.00	654,645,200.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	654,645,200.00	654,645,200.00
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	106,232,000.00	106,232,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	106,232,000.00	106,232,000.00
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	6,374,400.00	-
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	6,374,400.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		6,374,503.76
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		75,099,545.57

### **3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

---

Аудитаар 2,628.0 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залрууллаа. Үүнд

1. Үнэ төлбөргүй ирсэн 2,628.0 мянган төгрөгийн бараа материал орлогод аваагүй орхигдуулсан байна.

Аудитаар 18,024.1 мянган төгрөгийн зөрчил илэрч, 772.5 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 17,251.6 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлэв.

#### **3.1 Төлбөрийн акт**

1. Хоолны зардлын нормыг 772.5 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан.

#### **3.2 Албан шаардлага**

1. Тайлант хугацаанд 3 эд хариуцагч солигдоход хөрөнгийн тооллого хийгээгүй, хүнсний материалын 1,407.5 мянган төгрөгийн үлдэгдэлд тооллого хийж, тооцоо бодоогүй.

2. Хүнсний материалын үлдэгдлийг өмнөх оноос 7.4 дахин их буюу 15,844.1 мянган төгрөгөөр илүү нөөцөлсөн байна.

#### **3.3 Зөвлөмж**

Байхгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



**5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>				<b>1</b>		